



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 09

Өмнөдэлгэр сум

**Байгалийн нөөцийн хамтын менежментийн
нөхөрлөл байгуулахыг дэмжих тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.8 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалт, Хэнтий багийн иргэдийн Нийтийн Хурлын 2025 оны 06 дугаар тогтоол, Гурванбаян багийн 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Тавдугаар Хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1.Өмнөдэлгэр сумын Хэнтий, Гурванбаян багийн нутаг дэвсгэрт иргэдийн оролцсон байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдийг үүсгэн байгуулсугай.

2.Үүсгэн байгуулагдсан нөхөрлөлийн нэрсийг хавсралтаар баталсугай.

3.Нөхөрлөлүүдийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жилийн эцэст тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Р.Энхтөр)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ПҮРЭВДОРЖ

Өмнөдэлгэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн
Тавдугаар Хуралдааны 09 дүгээр
тогтоолын хавсралт



Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлуудийн нэрс

д/д	Багийн нэр	Нөхөрлөлийн нэр
1	Хэнтий баг	Сайхан Өндөр
2		Өгөөмөр
3		Овоот
4		Сууриа
5		Мангирт
6		Баян-Өлзийт
7		Чандмань
8		Нөөлөгт
9	Гурванбаян баг	Баянборт
10		Баялаг номт
11		Жавхлант
12		Хулст толгой
13		Яргайт